

ДУНДГОВЬ АЙМАГТ 2024 ОНЫ 4 САРД ХЭРЭГЖИЖ БУЙ
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН

2024 оны 05 дүгээр сарын 09

Мандалговь хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн сар бүрийн шийдвэрийн заалтуудыг хяналтад авахуулан эзэнжүүлж, хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ, үнэлгээг сар бүр тасралтгүй хийж үр дүнг үнэлэх, дүгнэлт гаргах, цаашид шийдвэр гаргах түвшинд арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн хэрэгжилтийн бодит үр дүнг нэмэгдүүлэхэд оршино

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэхдээ тайлан, мэдээлэл ирүүлсэн үйл явц, үр дүнг нотолж буй баримтад тулгуурлан хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-д заасан үнэлгээ өгөх аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан /unelgee.gov.mn/-д байршуулсан 77 шийдвэр: Засгийн газрын тогтоол-56, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл-52, Засгийн газрын албан даалгавар-5 нийт 113 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж 85.9 хувиар үнэлэв.

Хэрэгжилтийн үнэлгээний үе шат тус бүрээр нь авч үзвэл:

- Бүрэн хэрэгжсэн 73 заалт нь нийт заалтын 64 хувийг
- Хэрэгжих шатандаа байгаа 19 заалт нь 17 хувийг
- Хэрэгжилт хангалтгүй хэрэгжсэн 13 заалт нь 11 хувийг
- Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй болон аймагт хамааралгүй заалтууд 8 заалт 0.7 хувийг эзэлж байна.

Дундговь аймагт хэрэгжиж байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жагсаалт болон хэрэгжилтийн явцыг Dundgov.gov.mn сайт, төрийн байгууллагын цахим программ болох erp.e-mongolia.mn программын файлын сан хэсэгт байршуулахаас гадна мэдээллийн самбарт байршуулан мэдээллээр ханган ажиллаж байна. Мөн явцын хяналт шинжилгээгээр төрийн байгууллагуудыг мэдээллээр хангаж, хэрэгжилтийн явцад тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс харахад Засгийн газрын албан даалгаврын хэрэгжилтүүд 94 хувьтай буюу үр дүнтэй хэрэгжсэн байна. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 84 хувийн хэрэгжилттэй байгаа нь хөрөнгийн асуудлаас болон цаг хугацаанаас шалтгаалан хэрэгжих шатандаа явж байна гэж үзэж болохоор байна.

Шинээр батлагдан гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг танилцах хуудсаар цохолт хийж, харьяа хэлтсүүд хяналтдаа авахаас гадна төрийн байгууллагын цахим системд бүх төрийн албан хаагчдад нээлттэйгээр байршуулж хяналтад авч байна.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Аймгийн хэмжээнд 4 сарын байдлаар хэрэгжиж буй холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 85.9 хувьтай байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн удаашралтай хэрэгжиж байгаа 13 заалтын хэрэгжилтийг авч үзвэл Санхүүжилтээс шалтгаалсан-3, Урт хугацааны туршид хэрэгжих-2, Зохион байгуулалтаас шалтгаалсан-8 заалт байна. Удаашралтай хэрэгжиж байгаа заалтуудын бодит үр дүнг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох бодлогын хэлтсүүд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах үүднээс Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтуудыг хяналтад бүрэн авах, тайлагнахад анхаарах зарим асуудлын талаарх сургалт, нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж ажилласнаар тодорхой үр дүн гарч байна.

Хяналтад байгаа хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгаврын хэрэгжилт бүрэн хэрэгжиж дууссан, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон нэг удаагийн шинжтэй 19 заалтыг түүвэрлэн хяналтаас хасуулах тэмдэглэгээг нэг бүрчлэн цахим системд орууллаа. /Хяналтаас хасуулах саналын дагуу unelgee.gov.mn цахим программаас хяналтаас хасахгүй нээгдэж сар бүр хэрэгжилт гаргах нь аль аль талдаа хүндрэл бэрхшээлтэй байна гэж үзэж байна/

ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ / ЗӨВЛӨМЖ /

“ТӨРИЙН ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТЭС”-Т

1.Хэрэгжилт нь тогтмолжсон болон тусгайлан он зааж хугацаандаа бүрэн хэрэгжээд дууссан, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан саналуудыг хяналтаас хасуулах саналаа ирүүлж хэвших.

2.Шинээр гарч буй хууль тогтоомж,тогтоол шийдвэрүүдийг сурталчлах, иргэдэд мэдээлэх ажлыг эрчимжүүлэн ажиллах.

3.Хууль тогтоомж,тогтоол шийдвэрийн сар бүрийн хэрэгжилтийг нотлох баримттай тайлагнаж хэвших.

4. Хууль тогтоомж,тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнахдаа санхүүжилтыг тодорхой тайлагнаж ирүүлэх.

Хяналт- шинжилгээ, үнэлгээний хэлтэс